

# МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

## ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№20/524

ШУС, НУС

2019

### ЭКОЛОГИО ӨМӨӨРДӨГ “ЭРЭН СУРВАЛЖЛАГЧ”-ИЙН УР ЧАДВАРЫГ ҮНЭЛЭХҮЙ

Б.Баярмаа\*

\*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн багш, магистр (МА)

**Түлхүүр үг:** сурвалжлага, эх сурвалж, сэтгүүлчийн ур чадвар, экологийн сэтгүүл зүй, эрэн сурвалжлах сэтгүүл зүй

**Х**үүгээ тэвэрсэн ээж үхэлтэй тэмцэлдэж явсаар ОХУ-ын хил давж, ор сураггүй болсон эмгэнэлт үйл явдлын талаарх сурвалжлага 2012 оны есдүгээр сарын 9-нд “Өдрийн сонин”-д нийтлэгдэж, улс даяар дуулиан болсон билээ. Нутгийн иргэд Сэлэнгэ голыг гаталж байхад мөс цөмөрч, 27 настай Н.Саранчимэг найман сартай хүүтэйгээ их усанд урсан одсон үйл явдлын мөрөөр сэтгүүлч Э.Хүрэлбаатар орж, хэргийн гэрчүүд, нутгийн иргэдтэй уулзан сурвалжлахдаа ээж, хүү хоёрын эмгэнэлт хувь заяа хийгээд тэдний амийг аварч чадаагүй орон нутгийн онцгой байдлын газрынхны уруу дорой байдлыг харуулан, шүүмжилжээ. Ганц завинаас өөр “зэвсэггүй”, зориулалтын хувцас, бүр гар чийдэн ч үгүй онцгой байдлын аврагч нар даргын тушаал хүлээсээр ээж, хүү хоёрын араас нэхэж, амийг нь авраагүй юм гэхэд ар гэрийнхэнд нь цогцсыг нь ч олж өгч чадаагүй нь орон нутагт онцгой байдлын салбар ёроолдсоныг илчилсэн юм.

“Өдрийн сонин”-д, цаашлаад өдөр тутмын сонины уран бүтээлчид дундаас эрэн сурвалжилсан шинжтэй цуврал сурвалжлага, байгаль, хөдөөгийн буйд амьдралыг урнаар дүрсэлсэн аян замын тэмдэглэлээрээ сэтгүүлч Э.Хүрэлбаатар танигдсан. Тэрбээр “Зүүн гурван аймгийн хуульгүй ардууд зээрийн сүргээ хүйс

тэмтрээд дуусч байна” цуврал сурвалжлага, “Би Монгол Улсаа дэлхийн том орон гэж боддог буюу Хануйн бага сургуулийн сурагчид”, “Бөгтөр бөхөнгийн мөхөл ирэв үү” зэрэг бүтээлүүдээрээ 2015 оны шилдэгийн шилдэг сэтгүүлч болсон. Мөн 2013, 2018 онуудад ч оны шидэг сэтгүүлчдийн тоонд багтсан юм.

Э.Хүрэлбаатар жилд дунджаар 20 орчим удаа томилолтоор ажиллаж, хэн нэгний эрх ашгийг ноцтойгоор зөрчиж буй асуудлын хойноос явдаг, сурвалжилдаг. Тухайлбал, экологийн сэдэвтэй “Зүүн гурван аймгийн хуульгүй ардууд зээрийн сүргээ хүйс тэмтрээд дуусч байна”, “Галбын говийн хүрэн тэмээд халдварт “ботулизм” өвчин туссан уу”, “Алтан Туул, алтан Туул” хэмээн сүсэглэх гол маань алттай арваадхан айлын Туул болжээ”, “Дэлгэр суманд алт гарч, аймаг аймгийн нинжа нар цуглажээ” зэрэг цуврал нийтлэлүүд нь олны анхаарлыг татаж чадсан, үр нөлөөтэй бүтээлүүд юм. Эдгээрээс “Зүүн гурван аймгийн хуульгүй ардууд зээрийн сүргээ хүйс тэмтрээд дуусч байна” дөрвөн цуврал сурвалжлагыг сонгож, сэтгүүлчийн ур чадварыг үнэлэхээр зорилоо.

“Өдрийн сонин”-ы 2014 оны №295, №296, №297, №298-т нийтлэгдсэн “Зүүн гурван аймгийн хуульгүй ардууд зээрийн сүргээ хүйс тэмтрээд дуусч байна” [сүүлийн хоёр цуврал нь “Монголчуудын сувдаг шунахай сэтгэлийн гайгаар цагаан зээр устаж дууслаа” гарчигтай нийтлэгдсэн] цуврал нь экологийн сэдэвтэй сурвалжлага юм. Сэтгүүлч Э.Хүрэлбаатар иргэний

мэдээллийн мөрөөр өөрөө үйл явдлын оролцогч болж, Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгуудын нутагт цагаан зээрийн сүрэг автомат буу барьсан хууль бус анчид, балмад этгээдүүдийн гарт хүчин мөхөсдөж, хэдэн зуугаараа хядуулан цусан зам татаж буйг нүдэнд харагдтал өгүүлжээ.

Сэтгүүлч үүр дөнгөж хаяарч байхад Асгатын уулын баруун мөрөөр цагаан зээр агнаж буй хүмүүстэй уулзахаар давхина. Гурван машины мөрөөр орсон боловч тэд хууль, хяналтынхан гэж эндүүрсэн бололтой гурван тийшээ салан одсон бөгөөд сэтгүүлч машинаасаа буун эргэн тойрноо ажиглаад *“Машины гэрэлд турьхан хөлөө тас буудуулж санжлуулсан, бүх бие нь тэр чигтээ цусанд будагдаж, бууны суманд шүүрэн шанага шиг, сэг болтлоо буудуулсан цагаан зээрээр хөндий тал дүүрсэн гэлтэй... Эмгэнэлтэй хувь тавилан гэдэг л энэ буюу”* хэмээн санаа алдаж буйгаар сурвалжлага эхэлнэ. Ийнхүү гурван аймгийн нутгаар явж хулгайн анчид, нутгийн иргэдтэй уулзан цагаан зээрийн сүргийг хэрхэн хүйс тэмтэрч буйг өгүүлнэ. Цагаан зээрийг малын бэлчээр талхаллаа гэж нутгийнхан ад үзэж, харин ч ийнхүү олноор нь авлаж байгаад талархан суух бол цагаан зээрийн махыг хот руу үнэ хүргэн зардаг сүлжээ хүртэл бий болсон. Цэргийн ангийнхан, уул уурхайн компаниуд үнэгүй гэж идэш хийдэг бол хулгайн анчид зугаагаа гаргана. Харин эрх баригчид нь албан тушаалын төлөө тэмцэлдэж, энэ их хядлагыг зогсоох, цагаан зээрийн сүргийг өмөөрөх хүнгүй болсныг анхааруулснаар сурвалжлага өндөрлөжээ.

Сурвалжлага гэдэг нь сэтгүүлч өөрөө оролцсон үйл явдлынхаа тухай сэтгэл хөдөлгөм бөгөөд ил шууд өгүүлдэг бичлэгийн шуурхай зүйл<sup>1</sup> гэж үздэг. Харин Э.Хүрэлбаатарын *“Зүүн гурван аймгийн хуульгүй ардууд зээрийн сүргээ хүйс тэмтрээд дуусч байна”* сурвалжлага нь энэхүү онолыг практикт баталсан сайн жишээ гэж болно. Сэтгүүлч өөрөө үйл явдалд оролцохдоо нийтлэлийг идэвхтэй байр сууринаас бичсэнээр уншигчид үзүүлэх нөлөө нь нэмэгддэг. Мөн энэ нь

эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хамгийн үр дүнтэй аргууд болох ажиглалт, ярилцлагын аргыг ашиглах боломж олгодог, үүнийг ч сэтгүүлч сурамгай хэрэглэжээ.

**Э**.Хүрэлбаатарын ур чадварын онцлог нь дүрслэлийг чадмаг ашигладаг явдал. Тухайлбал, *“Цагаан зээрийн хядлага болсон газраас урагш хөдөлж, замгүй давхилаа. Унаж яваа машинд саатах юм үнэндээ алга. Жалга, гуу, чулуу, хад огт байхгүй. Зөвхөн л зах хязгааргүй шаргал тал, хялганын толгой салхинд сэвээнэх юм. Ийн явж байтал дахиад л зээр агнасан газарт яваад очдог юм байна. Дөрөө шүргэм өвсний толгойд цагаан зээрийн цус үсэрч, хөлджээ. Цусны дусал бөнжийж хөлдөөд хялганын толгой бөхийсөн байв. Энэ жил туранхай орсон болов уу гэмээр шаргачингийн толгой дээгүүр машины дугуй гарчихжээ. Машинд дайрагдсан зээрийн толгой, нүд нь бяцарсан харагдана. Тэрүүхэн цаахна мөн л нэг нас бага болов уу гэмээр жижиэхэн биетэй зээр гилжийн хэвтэж байлаа”* гэх зэрэг товч, тодорхой атлаа сэтгэл хөдлөл мэдрэгдсэн дүрслэлүүд олон таарна. Экологийн сэдэвтэй нийтлэл нь бусад сэдвээс [эдийн засаг, эрүүл мэнд зэрэг] сэтгэл хөдлөлийн өнгө аясаар ялгардаг. Энэ нь тухайн асуудал уншигчид хамаатай мэт сэтгэгдэл төрүүлдэг, экологийн асуудал ямар нөлөө үзүүлж буйг ул суурьтай дүрслэхэд тусалдаг<sup>2</sup>.

Мөн зээрийн сүргийг буудаж буй хүүг компьютер тоглоом тоглож буйтай нь зүйрлэсэн нь оновчтой болжээ. *“...Аавтайгаа хамт яваа арав гаруй насны хүү машиныхаа лүүкийг онгойлгочихсон шүршээд байх. Бууны суманд оногдсон зээр тэрий хадан газар шаан унаад тэр хавийн цас, өвс цусанд будагдах ажээ. Тэр хүүгийн нүдэнд бууны суманд оногдон унах цустайгаа холилдсон цагаан зээрийг харах үнэхээр бахдалтай байгаа бололтой... Restal ертөнц дэх тоглоом шигээ санаж огт цус гаргахгүй, хэнд ч гэм хор болохгүй юм шиг л ойлгож байна уу гэлтэй хүйс тэмтэрчихээд, юу ч болоогүй юм шиг давхин одлоо”* гэжээ.

Э.Хүрэлбаатарын бичлэгийн онцлог нь товч, тодорхой, богино өгүүлбэр. *“Цагаан зээрийн хядлага болсон газраас урагш хөдөлж, замгүй давхилаа. Унаж яваа машинд саатаарах юм үнэндээ алга. Жалга, гуу, чулуу, хад огт байхгүй”* гэх зэргээр ихэвчлэн нэг өгүүлбэрт 10-аас доош үг багтаажээ. Энэ нь сурвалжлагын ойлгомжтой, хүртээмжтэй чанарыг нэмж байна.

Гэвч сэтгүүлч Э.Хүрэлбаатарын дээрх цуврал бүтээлд засаж, залруулбал зохилтой дутагдлууд бас байна. “Зүүн гурван аймгийн хуульгүй ардууд зээрийн сүргээ хүйс тэмтрээд дуусч байна” сурвалжилгын эх сурвалжууд тодорхойгүй байна. Дөрвөн цуврал сурвалжлагад нийт 21 эх сурвалж дурдаж, мэдээлэл авчээ. Гэвч ганцхан тохиолдолд л эх сурвалжийн нэрийг дурдсан нь нутгийн айлын гэрийн эзэд болох н.Батсүрэн, н.Намжилдорж нарынх байв. Харин бусад тохиолдолд эх сурвалжийн нэр, албан тушаал зэрэг тодорхой мэдээлэл алга. Эх сурвалж тодорхойгүй байгаа нь нийтлэлийн итгэн, үнэмшүүлэх чадварыг бууруулдаг сул талтай. Цаашлаад сэтгүүлч санаанаасаа зохиосон мэт сэтгэгдэл төрүүлэх нь бий. Жолооч, жийптэй залуус, цагдаа нар, нутгийнхан, малчин, хулгайн анчид, жагсагчид, гэрийн эзэд, ченжүүд зэргээр ерөнхийлсөн нь эх сурвалжийн өгүүлсэн баримт үнэн эсэхэд эргэлзээ төрүүлэхээр байна.

Сэтгүүлч эрэн сурвалжлах сэтгүүл зүйн далд ажиглалтын арга ашиглаж, өөрийгөө сэтгүүлч гэдгийг хэлэхгүйгээр мэдээлэл авсан тохиолдол олон байна. Ийм тохиолдолд эх сурвалжийн нэрийг дурдаагүй гэж бодъё. Хулгайн анчид, махны ченжүүдийн нэр ус, автомашины дугаарыг ил болгох боломжгүй байлаа ч наад зах нь мэдээлэл өгсөн нутгийн иргэний нэр, баг, сумынх нь нэр, цагдаа болон мэргэжлийн хяналтын ажилтны нэр, албан тушаалыг тодорхой дурдах ёстой. Нэрээ нууцлахыг хүссэн эх сурвалжаа хүндэтгэх нь зүйн хэрэг. Гэхдээ ач холбогдол багатай, гэм хоргүй мэдээлэл өгч буй

эх сурвалжийн нэрийг нууцлах нь эргээд бүтээлийн үр нөлөөг бууруулжээ.

Сэтгүүл зүй бол бодит байдал, баримтыг чиг шугамаа болгодог мэдээллийн үйл ажиллагаа. Гэтэл баримтыг нь шалгах боломжгүй “нутгийнхан тэгэж байна”, “цагдаа нар тэгэж байна” гэж дам сургаар бичих нь зохисгүй. “Хөдөө талд нь зээрийн хядлага болж байхад Дорнод аймгийнхан “Юун зээр. Тэр муу зээр яадаг юм, буудуулж үхээ л биз. Энд Засаг даргаа огцруулах гээд жинхэнэ хор найрагдаж байхад” гэгцгээгээд тоох ч хүүхэд алга, тэнд....Харин Сүхбаатар аймгийнхан “Бид хоёр ч удаа хөдөөгүүр яваад шалгасан. Цагаан зээрийн хядлага гэж байхаа больсон гээд л сууж байх” гэх зэргээр тодорхой бус эх сурвалж ашигласан тохиолдол олон байна.

Экологийн сэдэв нь олон хүчин зүйлтэй холбоотой, шинжлэх ухааны нарийн мэдлэг шаарддаг учраас мэргэжлийн судлаач, албаны хүнээс мэдээлэл авах нь чухал. Мөн олон ургальч байдлаас хандахад аль болох олон түвшний, олон эх сурвалж шаардлагатай байдаг билээ.

Экологийн сэдэвтэй нийтлэл, нэвт-рүүлгийн нэг онцлог нь хохирч буй байгаль экологи, амьтдын талаар танин мэдэхүйн мэдээлэл өгдөг. Ингэснээр уншигчийн сонирхлыг татаж, оролцоог нь мэдрүүлдэг. Харин уг дөрвөн цуврал сурвалжлагын нэгд нь л цагаан зээрийн тоо толгой болон байгаль орчиндоо гэм хор учруулдаггүй талаар хоёр багц мэдээлэл л оруулжээ.

Сэтгүүлч Э.Хүрэлбаатарын үйл явдлын уран дүрслэлүүд, сэтгэл хөдлөл шингэсэн хурц атлаа товч тодорхой өгүүлбэрүүд уншигчдын анхаарлыг татаж чадсан. Гэхдээ агуулга давхцах тохиолдол цөөнгүй байна. Сэтгүүлч гурван аймгийн нутгаар явахдаа цагаан зээрийн сүргийг хядаж буй хууль бус анчидтай олон таарсан учир тэр их хядлагыг өгүүлсэн дүрслэлүүд цуврал бүрт олон дурдагдах нь аргагүй. Харин сэтгүүлчийн уншигчдын анхаарлыг хандуулах гэсэн санаанууд олон давтагдсан нь сунжруу болгожээ. Тухайлбал, нутгийн иргэд цагаан зээрийг идшэндээ

хэрэглэж буй талаар эхний гурван цувралд гурвууланд нь дурджээ. Мөн цагаан зээрийн махыг дамлан зардаг сүлжээ, ченжүүдийн талаарх мэдээлэл сүүлийн гурван цувралд давхацсан байна. Орон нутгийн уул уурхайн компани болон цэргийнхэн идшэндээ зээр агнадаг гэдэг баримт, санааг мөн гурван цувралд давтсан байна. Ингэснээр нийтлэлийн багтаамж, ашигтай мэдээллийн орон зай багасчээ. Үүний оронд нутгийнхны хандлага, хуулийнхны үл тоомсорлосон байдал, махны ченжүүд гэх зэргээр агуулгуудыг цуврал тус бүрд хуваан зохиомжилсон бол нийтлэлийн үр нөлөө улам нэмэгдэх юм.

**Х**эл найруулгын хувьд анхаарвал зохих нэг дутагдал байна. Хэтрүүлэл бол уран зохиолд түгээмэл ашигладаг арга. Харин экологийн сэтгүүл зүйд ашиглах нь зохисгүй бөгөөд үнэмшилгүй, нөхцөл байдлын бодит чанарыг алдагдуулдаг<sup>3</sup>. Ийм дутагдал дээрх сурвалжлагаас ажиглагдлаа. *“Ер нь нутгийн малчид бүгд цагаан зээрийг үнэн сэтгэлээсээ үзэн ядна. “Цагаан зээрийг хядаад байгаарай. Хурдан дуусаасай гэнэ” гэсэн нь сэтгэл хөдлөлөөр хэтрүүлсэн явдал болжээ. Сэтгүүлчийн уулзсан Дарьганга сумын малчин “Би уг нь цагаан зээрийг хамгаалах юмсан гэж бодож явдаг хүн. Өнгөрсөн жил цагдаад зээрийн ангийн талаар хэлсэн. Бөөн юм болж, сүүлдээ мэдээлэл өгснөөсөө болоод буруудаж эхэлсэн. Одоо бол ямар ч хэл чимээгүй, зээр буудаж байсан ч нүдээ аниад хараагүй юм шиг л явдаг болсон... Зээр үнэндээ ямар ч гэм хоргүй амьтан юм ш дээ” хэмээжээ. Үүнээс үзэхэд арай ч нутгийн бүх иргэд цагаан зээрийг үнэн сэтгэлээсээ үзэн яддаггүй аж.*

Ийнхүү хэтрүүлсэн нь эргээд логик зөрчилд хүргэсэн байна.

Сэтгүүлч Э.Хүрэлбаатарын “Зүүн гурван аймгийн хуульгүй ардууд зээрийн сүргээ хүйс тэмтрээд дуусч байна” цуврал сурвалжлага нь эрэн сурвалжилсан бүтээл мөн эсэх талаар хэдэн үг тэмдэглэе. Сэтгүүл зүйн эрэн сурвалжилсан бүтээл нь “... олон түмний сонорт хүрээгүй, хэн нэгэн нуун дарагдуулахыг хүссэн тэр баримтыг ил гаргах ёстой бөгөөд хөндөж буй асуудал, сэдэв нь олон нийтийн эрх ашигт нийцсэн, нийгмийн ач холбогдолтой байх шаардлагатай<sup>4</sup>. Энэ тодорхойлолтоор авч үзвэл дээрх сурвалжлага нь “олон түмний сонорт хүрээгүй, хэн нэгэн нуун дарагдуулахыг хүссэн баримтыг ил гаргах ёстой” гэсэн эхний шаардлагыг хангахгүй байна. Цагаан зээрийн сүргийг хууль бусаар, үй олноор нь агнаж буй явдлыг өмнө нь сэтгүүлчид мөн хөндөж байжээ. Тухайлбал, 1998 онд “Ардын эрх”-сонинны №304-д сэтгүүлч Б.Батбилиг “Цагаан зээрээ агнах уу, аргадах уу”, “Өдрийн сонин”-ы сэтгүүлч Ж.Гангаа 2010 онд “Хялганатын талын цагаан зээр хар цээр биш ээ” гэсэн гарчигтай нийтлэлд мөн дээрх асуудлыг хөндөн бичиж байв.

Б.Батбилэгийн “Цагаан зээрээ агнах уу, аргадах уу” нийтлэлд “Зүүн гурван аймгийн хуульгүй ардууд зээрийн сүргээ хүйс тэмтрээд дуусч байна” сурвалжлагад

дурдсан баримт, санааг мөн дурдаж байжээ. Тухайлбал, *“Цагаан зээрийн тоо толгой цөөрч буйн өөр нэг шалтгаан нь ил, далд аргаар, олон тоогоор түүнийг намнаж буй явдал. Жилд дунджаар 70-80 мянган зээрийг хууль зөрчин агнаж байгаа гэсэн тооцоо байдаг юм байна.”*, *“Практикаас үзвэл урьд нь үйлдвэрлэлийн*



**Тогтмол хэвлэлүүдийн байгаль экологийн булан тогтмол бус, ийм сэдэвтэй мэдээлэлд бага зай талбай ногддог, сэдвийн хүрээ явцуу, нийтлэлийн чанар нь өнгөц, сул болсон. Ийм цаг үед Э.Хүрэлбаатарын эрэн сурвалжилсан шинжтэй экологио өмөөрсөн нийтлэлүүд залуу сэтгүүлчдэд урам зориг өгч, олон талаараа сайны жишээ болж чадна**





зориу-лалтаар агнасан зээрийн махыг гол төлөв сургуулийн дотуур байр, цэргийн болон хорих ангийн хоолонд хэрэглэдэг. Сүүлийн үед зах зээлийн байдлаас болж гадагш экспор-толж ашиг олох сонирхол давамгайлах болжээ” гэжээ. Э.Хүрэлбаатарын сурвалжлагын гол санаа болох цагаан зээрийг олноор нь хууль бусаар агнаж, нутгийнхан, цэргийнхэн, хорих ангиуд хүнсэндээ хэрэглэж буйг ийнхүү өмнө нь хөндөн бичиж байв. Уг нийтлэлд “Өнгөрсөн онд явуулсан тооллогоор 2.2 сая толгой цагаан зээр байгаа гэсэн тооцоо гарчээ. Үүний 90 шахам хувь нь Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Дорноговь аймгийн нутагт байдаг аж” гэсэн бол Э.Хүрэлбаатарын сурвалжлагад “Цагаан зээрийг сүүлийн жилүүдэд огт тоолоогүй юм байна. Арав гаруй жилийн өмнө Монголд хоёр сая орчим цагаан зээр байна гэх тоог гаргасан байна” гэж хуучин баримтыг тэрчигээр нь давтан өгүүлжээ.

Харин Э.Хүрэлбаатарын сурвалжлагын сэдэв нь олон нийтийн эрх ашигт нийцсэн, нийгмийн ач холбогдолтой байх шаардлагыг хангаж байна.

Сэтгүүлчид эрэн сурвалжилсан нийтлэл, нэвтрүүлэгтээ мэдээлэл өгөхөөс татгалзсан түшмэдүүдэд нөлөөлөх аргуудыг ашигладаг. Мэдээлэл өгөхөөс татгалзсан албан тушаалтны утасны дугаарыг нийтлэх, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээс тусламж хүсэх, “эх сурвалж”-ийн удирдлага, дээд шатны байгууллагад гомдол гаргах<sup>5</sup> зэрэг аргууд бий. Харин энэ сурвалжлагын хувьд сэтгүүлч албан тушаалтнаас мэдээлэл авч, эх сурвалжийн тэнцвэртэй байдлыг хадгалах талаар их хүч зараагүй нь ажиглагдлаа. Гэхдээ энэхүү цуврал сурвалжлагыг бэлтгэхдээ ил, далд ажиглалт, ярицлагын аргыг оновчтой ашигласан, асуудлыг судлан, эрж хайсан зэргийг харгалзан эрэн сурвалжилсан шинжтэй гэж үзэж болохоор байна.

Өнөөдөр ингэж хэдэн зуун км дамжин томилотод явдаг сэтгүүлч, явуулдаг редакц ч гэж ховор болсон. Харин Э.Хүрэлбаатар байгалийн орчныг сүйтгэж буй тохиолдлын араас уйгагүй сурвалжилж,

үр дүнд хүрч байгаа нь сайшаалтай. “Зүүн гурван аймгийн хуульгүй ардууд зээрийн сүргээ хүйс тэмтрээд дуусч байна” сурвалжлагын мөрөөр хуулийнхан хяналтаа чангатгаж, мэргэжлийн хяналтын байгууллага хяналтын цэгийнхээ тоог нэмсэн юм.

**Ө**дгөө экологийн сэдэвтэй нийтлэл, нэвтрүүлгийн тоо 1980 онтой харьцуулбал эрс багассан. Тогтмол хэвлэлүүдийн байгаль экологийн булан тогтмол бус, ийм сэдэвтэй мэдээлэлд бага зай талбай ногддог, сэдвийн хүрээ явцуу, нийтлэлийн чанар нь өнгөц, сул болсон. Ийм цаг үед Э.Хүрэлбаатарын эрэн сурвалжилсан шинжтэй экологио өмөөрсөн нийтлэлүүд залуу сэтгүүлчдэд урам зориг өгч, олон талаараа сайны жишээ болж чадна.

#### Ишлэл

- 1 Норовсүрэн Л. 2005. Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйл. УБ., х. 87.
- 2 Ариун Л. 2008. Монголын тогтмол хэвлэлийн экологийн нийтлэл. УБ., х. 42.
- 3 Ариун Л. 2008. Монголын тогтмол хэвлэлийн экологийн нийтлэл. УБ., х. 117.
- 4 Зулькафиль М. Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн онол, практик. УБ., 2015. х. 16.
- 5 Зулькафиль М. Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн онол, практик. УБ., 2015. х. 115.

#### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Б.Батбилэг. “Цагаан зээрээ агнах уу, аргадах уу” // “Ардын эрх”. 1998.12.24, №304.
2. Э.Хүрэлбаатар. “Зүүн гурван аймгийн хуульгүй ардууд зээрийн сүргээ хүйс тэмтрээд дуусч байна” // “Өдрийн сонин”. 2014 он. №295- №298.
3. Ж.Гангаа. “Хялганат талын цагаан зээр хар цээр биш ээ” // “Өдрийн сонин”. 2010.10.11.
4. Ч.Чойсамба. Сонины хэл найруулга. УБ., 2000.

#### Summary

In this article, the professional skills of journalist Khurelbaatar of Mongolian daily newspaper “Daily news” are considered. Therefore, the series of interview titled “Folks in eastern three provinces have extinguished the herd of white antelope” were analyzed in terms of ecological and investigating journalism aspects.